



МОНГОЛ УЛС
ТӨВ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2019 оны 11 сарын 01 өдөр

Дугаар А/591

Зуунмод

Газар эзэмших эрх шилжүүлэх
тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.3, 29.2, Газрын тухай хуулийн 38 дугаар зүйлийн 38.1, 38.4 дэх заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Иргэн Дорж овогтой Туяа /НЭ63021208/-ын Номт 1-р баг, Бугатын 216 тоотод амины орон сууцны зориулалттай 400 м² газрын эзэмших эрхийг Цогтсайхан овогтой Насанжаргал /НН77102979/-д 15 жилийн хугацаагаар эрх шилжүүлсүгэй.

2. Газар эзэмшигч Ц.Насанжаргалд дараах үүргийг хариуцуулсугай.

2.1. Газрыг зориулалтын дагуу ашиглах.

2.2. Газрын кадастрын зураглалыг мэдээллийн санд бүртгүүлж баталгаажуулан газар эзэмших эрхийн гэрчилгээг авах.

2.3. Газар эзэмших гэрээ байгуулж, гэрээг жил бүр дүгнүүлэн газрын төлбөрийг хугацаанд нь бүрэн төлж байх.

2.4. Эзэмшил газрын төлөв байдлын чанарын хянан баталгааг 5 жилд нэг удаа хийлгэх.

3. Аймгийн Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газар /М.Отгонбат/, Зуунмод сумын Засаг дарга/Г.Монхбадрал/ нарт дараах ажлыг үүрэг болгосугай.

3.1. Газар эзэмшигчтэй гэрээ байгуулж дүгнэж ажиллах.

3.2. Газрын мэдээллийн санд бүртгэж, гэрчилгээг олгох.

3.3. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавих.

4. Энэ захирамж гарсантай холбогдуулан аймгийн Засаг даргын 2019 оны 01 дүгээр сарын 15-ны өдрийн А/29 дүгээр захирамжийн Д.Туяад холбогдох хэсэг болон газар эзэмших эрхийн 000027818 дугаартай гэрчилгээг тус тус хүчингүй болсонд тооцсугай.

ЗАСАГ ДАРГА Ж.БАТЖАРГАЛ

